



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
СҮМБЭР СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 1/15

Сүмбэр сум

Байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хороог  
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх заалт, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын хуралдаанаар хэлэлцэн ний олонхын хамгийн өндөр санал авсан дараах албан хаагчдыг байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хорооны гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ёс зүйн дэд хорооны дарга

Э.Даваадорж

(Сумын Засаг даргын орлогч)

Гишүүд:

Б.Уранчимэг

(Байгаль орчны хяналтын Улсын  
байцаагч)

Г.Оюунболор

(2-р багийн Нийгмийн ажилтан)

Д.Хишигцэцэг

(Архив, албан хэрэг  
хөтлөлт хариуцсан ажилтан)

Ш.Ариунсан

(Хууль эрх зүйн мэргэжилтэн)

Нарийн бичиг:

2. Байгууллагын дэргэдэх ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг хавсралтаар  
баталсугай.

422230019

Сумын Засаг даргын Тамгын  
газрын даргын 2023 оны 9 дүгээр  
сарын 13...ны өдрийн 11/15 дугаар  
тушаалын хавсралт

## Сүмбэр сумын Засаг Даргын Тамгын Газрын ёс зүйн дэд хорооны ажиллах журам

1. Төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар эцэслэн дүгнэж, шийдвэр, дүгнэлт гаргах, эрх бүхий “Ёс зүйн дэд хороо” нь 5 хүний бүрэлдэхүүнтэй, 5 жилийн хугацаатай Сүмбэр сумын ЗДТГ-ын дэргэд ажиллана.

2. Ёс зүйн дэд хороо нь Монгол Улсын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллана.

3. Ёс зүйн дэд хороо нь жил бүр ажлын төлөвлөгөөгөө батлуулсан байгууллагын ажилтан албан хаагчдад ёс зүйн харилцаа хандлагыг дээшлүүлэх ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажил арга хэмжээг зохион байгуулсан, хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, ёс зүйн зөрчлийн талаар ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээг тухай бүр аймгийн төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлнэ.

4. Ёс зүйн дэд хороо нь төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол мэдээллийг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 15 дугаар зүйлийн /Гомдол мэдээллийг хянан шийдвэрлэх/ дагуу шалгаж, ирүүлсэн танилцуулга материалыг гишүүдийн ердийн олонхийн ирцтэй хуралдан хэлэлцэж, шалгалтын дүнг үндэслэлтэй гэж үзвэл зөрчлийн шинж чанарыг харгалзан, зөрчил гаргачид хариуцлага хүлээлгэнэ. .

5. Ёс зүйн зөрчилд холбогдсон албан хаагчийг хуралд биечлэн оролцуулж тайлбарыг сонсож, асуулт тавьж, хариулт авч болно.

6. Ёс зүйн дэд хорооны дүгнэлтээр тухайн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол түүнд албан ёсоор мэдэгдсэнээр хариуцлагыг сайн дураараа хүлээх боломж олгоно.

7. Ёс зүйн дэд хороо тухайн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй гэж үзвэл гомдол , мэдээлэл гаргасан иргэн, байгууллагад энэ тухай бичгээр хариу өгнө.

8. Ёс зүйн дэд хороо нь албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг тухайн төрийн албан хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэж, байгууллагын дотоод сүлжээнд байршуулсан мэдээлнэ.

9. Төрийн албан хаагч ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар эцэслэн дүгнэж, шийдвэр гаргах, эрх бүхий “Ёс зүйн зөвлөл” нь 3 хүний бүрэлдэхүүнтэй, 3 жилийн хугацаатай Сүмбэр сумын ЗДТГ-ын дэргэд ажиллана.

10. Ёс зүйн Зөвлөл нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллана.

11. Ёс зүйн зөвлөл нь жил бүр ажлын төлөвлөгөөгөө батлуулсан байгууллагын ажилтан албан хаагчдад ёс зүйн харилцаа хандлагыг дээшлүүлэх ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажил арга хэмжээг зохион байгуулсан , ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, ёс зүйн зөрчлийн талаар

ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээг жил бүр хагас, бүтэн жилээр аймгийн төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлнэ.

12. Ёс зүйн зөвлөл нь төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол мэдээллийг “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 5 дахь хэсэгт заасны дагуу шалгаж, ирүүлсэн танилцуулга материалыг гишүүдийн ердийн олонхийн ирцтэй хуралдан хэлэлцэж, шалгалтын дүнг үндэслэлтэй гэж үзвэл зөрчлийн шинж чанарыг харгалзан, зөрчил гаргачид хариуцлага хүлээлгэх тогтоол гаргана.

13. Ёс зүйн зөрчилд холбогдсон албан хаагчийг хуралд биечлэн оролцуулж тайлбарыг сонсож, асуулт тавьж, хариулт авч болно.

14. Ёс зүйн зөвлөлийн тогтоолыг зөрчил гаргасан албан хаагчид танилцуулна.

15. Ёс зүйн зөвлөлийн тогтоолоор төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн

албан хаагчид зөрчлийн шинж байдлыг харгалзан сануулах болон учлалт гүйхыг үүрэг болгох хариуцлага хүлээлгэнэ.

16. Ёс зүйн зөвлөл тухайн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй гэж үзвэл гомдол, мэдээлэл гаргасан иргэн, байгууллагад энэ тухай бичгээр хариу өгнө.

17. Ёс зүйн зөвлөл нь албан тушаалтан төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг тухайн төрийн албан хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэж, байгууллагын дотоод сүлжээнд байршуулан мэдээлнэ.